


БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ 2020 ОНЫ ЭХНИЙ 9 САР

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 3.8 их наяд төгрөгт болж, 3.7 (97.9%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 79.8 (2.1%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 53.3 (1.4%) тэрбум төгрөгөөр буурахад дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 120.2 (3.4%) тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч гадаадын барилгын байгууллагынх 173.5 (68.5%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн.


Барилга угсралт, их засварын ажил, гүйцэтгэгчийн төрлөөр /тэрбум төгрөг/




Дотоодын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2020 оны эхний 9 сард 3.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 208.3 (6.0%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 375.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 288.5 (4.3 дахин) тэрбум төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагынх 59.6 тэрбум төгрөгт хүрч 40.0 (3.0 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Барилга угсралт, их засварын ажлын 36.1 хувийг орон сууцны бус барилга, 31.9 хувийг инженерийн барилга, байгууламж, 29.1 хувийг орон сууцны барилга, 2.9 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оны мөн үеэс инженерийн байгууламжийн эзлэх хувь 10.3 пунктээр, их засварын ажлынх 0.9 пунктээр тус тус өсөж, орон сууцны бус барилгын эзлэх хувь 10.7 пунктээр, орон сууцны барилгынх 0.5 пунктээр буурсан байна.


БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ /ХУВИАР/



Барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, төрлөөр /тэрбум төгрөг/




Орон сууцны бус барилга, төрлөөр /тэрбум төгрөг/



Орон сууцны бус барилгын гүйцэтгэл 2020 оны эхний 9 сард 1.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 427.7 (23.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд, орон сууцны бус бусад барилгын гүйцэтгэл 31.0 (12.9%) тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч үйлдвэрийн барилгын гүйцэтгэл 403.4 (43.0%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 39.0 (38.3%) тэрбум төгрөгөөр, худалдаа, үйлчилгээний барилгынх 10.2 (9.1%) тэрбум төгрөгөөр, сургууль, соёлын барилгын гүйцэтгэл 6.1 (1.5%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээ /тэрбум төгрөг/



Улаанбаатар хотод 2020 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.5 их наяд төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 41.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.8 пунктээр буурсан байна. Барилга угсралт, их засварын ажлын 59.0 хувийг аймаг, орон нутагт баригдаж буй барилга угсралт, их засварын ажил эзэлж байна.